

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1084
танай _____-ны № _____-т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох "Иргэдийн оролцооны нэгдэл нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

Дүгнэлт

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор "Иргэдийн оролцооны нэгдэл нам"-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Иргэдийн оролцооны нэгдэл нам"-ын мөрийн хөтөлбөр /...6... хуудас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030691



ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН 2024 ОНЫ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Хүний эрх, хувийн хэвшил, тогтвортой хөгжил, иргэний оролцоог эрхэм болгодог баруун төвийн намын хувьд Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН) “боловсрол, бизнесийн орчин, тогтвортой хөгжил” гэсэн гурван голлох чиглэлээр улс орныхоо хөгжилд дэвшилтэт өөрчлөлтийг авчрах зорилт тавин мөрийн хөтөлбөрөө дэвшүүлж байна. Үүнд:

Нэг: Боловсролын чиглэлээр

Боловсрол бол Монгол улсын өнөөдөр болон ирээдүйн гол хөрөнгө оруулалт юм хэмээн ИОНН үзэж буй тул “Ойрхон сургууль” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Энэхүү хөтөлбөр нь бага дунд болон насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагч нарын хөдөлмөр, бизнес эрхлэх боломжийг хангах, хүн амын суурь эрүүл мэндийн асуудлыг багасгах, хот байгуулалт, нийтийн тээврийн тулгамдсан асуудлыг эерэгээр шийдвэрлэх, хүүхдийг эрүүл аюулгүй орчинд өсгөж боловсролтой иргэн болгоход гүн гүнзгий нөлөө үзүүлэх болно. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд дараах шинэчлэлийг хийнэ.

- 1.1. Хүүхэд бүр явганаар болон аливаа тээврийн хэрэгслэлээр гэрээс сургууль, сургуулиас гэр хүртэл зорчиход 15 минутаас илүү хугацаа зарцуулахгүй байхаар эрх зүй, зохион байгуулалтын өөрчлөлт хийнэ.
- 1.2. Сургууль дээр өглөө цуглах, сургуулиас орой тарах цагийг уян хатан байдлаар зохицуулна.
- 1.3. Хүүхэд өглөө цуглахаас орой тарах хүртлээ сургууль дээрээ өдөрт 7-11 цагаар байж хөгжих тохитой нөхцлийг бий болгоно.
- 1.4. Уртасгасан цагаар сургууль дээр байх хугацаанд хүүхэд өсөлтийн үе шатандаа тохирсон өсөх хөгжих, эрүүл, аюулгүй орчинд байх боломжийг бүрдүүлэхэд боловсролын салбарын худалдан авалтын бодлогыг чиглүүлнэ.
- 1.5. Багш нар бол ирээдүйг бүтээгчид учир бухимдалгүй, аз жаргалтайгаар ажлаа хийх ёстой гэж ИОНН үзэж байна. Иймээс багш нарыг дэмжих бодлогыг тууштай баримтална.
- 1.6. Хүүхдийн сурах орчинд сургууль, анги танхим, багш, гэр бүл, сургуулийн эргэн тойрны зай талбай, орчны хөршүүд багтах тул сургуулийн үйл ажиллагааны дүрэм, сургалтын хөтөлбөр зэргийг дээрээс батлахыг халж, харин сургууль дундын сургалтын мэргэжилтэн, тухайн сургуулийн багш, эцэг эх, асран хамгаалагч нар хамтран баталдаг байхаар Боловсролын хуулинд өөрчлөлт оруулна.
- 1.7. Багш нарын ажлын ачааллыг бууруулах, аливаа шахалт дарамтыг багасгах үүднээс багш нар сургалтын хөтөлбөр, сургалтын ажлын төлөвлөгөөний

1

000000071



хүрээнд батлагдсан ажлаас өөр аливаа ажилд дайчлагдахгүй байх нөхцлийг хангана. Багш нарын хөдөлмөрийг хөнгөвчлөх, боловсролыг шинэ техник технологи, цахим хэрэгсэл ашиглан хүртээмжтэй олгоход чиглэсэн сургалтын техник туслалцааны тогтолцоо бий болгоно.

- 1.8. Хүн бүрийн сурч боловсрох чадавхи өөр өөр байдгийг хүлээн зөвшөөрсөн боловсролын бодлого явуулна.
- 1.9. Хүн бүрийн насан туршид сурч боловсрох эрхийг хангахуйц нээлттэй боломжийг орон нутаг бүрт, сургууль бүрт байлгана.
- 1.10. Сурах бичиг, дүрс болон дуу бичлэг зэрэг сургалтын агуулгатай холбоотой аливаа контентийг хүүхэд ойлгох шалгуураар хэмжинэ. Сургалтын контент багш заах, сурагчид сурахад хялбар байвал зохиогчид дэмжлэг үзүүлнэ.
- 1.11. Суралцаж буй оюутан, 12-оос доош насны хүүхэдтэй эцэг эхийн цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнаас ажиллах боломжийг хялбар, уян хатан, нээлттэй байлгах эрх зүйн орчин бий болгоно.

Хоёр. Бизнесийн орчны чиглэлээр: Шударга татвар- Тэгш орчин

Хувийн хэвшил бол улс орны эдийн засгийн гол хөдөлгөгч хүч гэж Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам үздэг учраас хувийн хэвшилд бизнесийн тэгш боломж, эрүүл өрсөлдөөний орчинг хангах нь бидний гол зорилтын нэг юм. Өнөөгийн бизнесийн орчин нь улс төр маш их холилдсон, цөөн хэдэн компани шударга бус давуу байдлаа ашиглан бусдынхаа бизнесийн орон зайг хумьсан, бизнес эрүүлээр өсөж өндийх, тэлэх нөхцөл алдагдсанаас үүдэн залуучууд эх орондоо бизнес хийхээс шантарч олноороо гадаад улс руу гарах болсон нь манай орны хөгжлийг хойш татах хэмжээнд хүрлээ гэж ИОНН үзэж байна. Иймээс татвар, төсөв, өрсөлдөөний бодлогыг доорхи байдлаар өөрчилж бизнесийн орчинг сайжруулна. Үүнд:

- 2.1. Татвар бол төрийн суурь, төсвийн орлогыг бүрдүүлэгч гол орлого мөн гэсэн зарчимд тулгуурлан аливаа татвараас чөлөөлөх хууль санаачлахгүй, батлахгүй. Татвар бол орлого төдийгүй бүртгэл мөн тул татвараас 100 хувь чөлөөлөх явдлыг таслан зогсооно.
- 2.2. Хэрэв татварын хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай хэмээн иргэдийн зүгээс нээлттэй хэлэлцүүлгээр үзсэн бол тухайн хуулийг санаачлагч болон үр ашгийг нь хүртэх боломжтой хувь хүн, байгууллага, компаниудын мэдээллийг нийтэд нээлттэй байлгана.
- 2.3. 2024 оноос өмнө ямарваа татвараас чөлөөлөгдсөн, татварын хөнгөлөлт эдэлсэн бизнес эрхлэгч хувь хүн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нийгэмд ямар үр нөлөөтэй байсан тухай нээлттэй сонсголыг зохион байгуулна. 2024 оноос өмнө татварын хөнгөлөлт, бүрэн чөлөөлөлт эдэлсэн бүх аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны талаар нээлттэй сонсгол зохион байгуулна.
- 2.4. Цаашид татварын хөнгөлөлт эдэлж буй ямарваа иргэн, аж ахуйн нэгж, тухайн татвар хөнгөлөх талаарх хууль, тогтоомж батлагдсанаас хойш 18 сарын хугацаанд татварын хөнгөлөлтийн үр нөлөөг тайлагнах сонсголд заавал

0000000000



- оролцож олон нийтэд тайлан тавьдаг байхыг хуульчилна. Хэрэв татварын хөнгөлөлтийн үйлчлэх хугацаа 5 жилээс дээш бол уг сонсголыг жил бүр зохион байгуулдаг байхаар хуульчилна.
- 2.5. Татварын хөнгөлөлт эдэлж үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, байгууллага, аж ахуйн нэгж нь тухайн заасан үйл ажиллагаанаас бусад бүх төрлийн ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахгүй байхыг хуульчилна.
- 2.6. Татварын хөнгөлөлтийн талаар хууль тогтоомж санаачлах үйл явцыг ил тод болгоно. Үүний тулд Лоббийн тухай хууль батлуулна. УИХ, ЗГ-ийн гишүүд, төрийн албан хаагчид лоббичтой уулзалт хийхдээ заавал уулзалтын тэмдэглэл хөтлөх, тэмдэглэлийг нийтэд нээлттэй байлгахыг үүрэгжүүлнэ. Татварын хөнгөлөлтийг санаачилж буй эрх бүхий этгээд болон түүнээс шууд үр ашгийг нь хүртэх хувь хүн, байгууллагын хооронд ашиг сонирхолын нэгдмэл сонирхол бий эсэхийг нээлттэй хэлэлцүүлж, хэрэв ашиг сонирхолын зөрчилтэй гэж үзвэл уг хуулийг УИХ-аар хэлэлцэхгүй байхаар хуульчилна.
- 2.7. Татварын хөнгөлөлтийн талаарх хууль тогтоомжийг санаачилж буй аливаа этгээд тухайн хууль, тогтоомжийг олон нийтээр хамгийн багадаа 18 сарын хугацаанд, эрх ашиг нь хөндөгдөх бүх талын оролцоог хангаж хэлэлцүүлэх ба тухайн зардлыг хууль санаачлагч, уг хуулиас ашиг хүртэх этгээд тус тус гаргана.
- 2.8. Төрийн өмчийн болон орон нутгийн өмчитт аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөр, сангуудаар татварын бодлого гажуудах, төсөвт төвлөрөх ёстой орлого урсаж алдагдах явдлыг цэгцэлнэ. Улсын төсвийг зөвхөн УИХ батлах бүрэн эрхтэй байна гэсэн Үндсэн хуулийн заалтыг ягштал мөрдүүлнэ.
- 2.9. Төрийн өмчийн аж ахуйн нэгж үндсэн үйл ажиллагаанаасаа өөр зорилгоор хөрөнгө оруулалт хийх, зээл авах нь Улсын төсвийг УИХ-аас далдуур баталж буй хэрэг гэж үзнэ. Төрийн өмчийн аж ахуйн нэгж үндсэн зорилгоосоо өөр зорилгоор хөрөнгө оруулалт хийх, зээл авах аливаа шийдвэрийг УИХ-аас баталсан Төсвийн тодотголгүйгээр гаргахыг хориглоно.
- 2.10. Төрөөс тогтоосон хатуу үнийн бодлоготойгоос бусад төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллага зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулалт хийх, нийт төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллага зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авалт хийх нь улсын төсвийг УИХ-аас гадуур баталж, зарцуулж буй хэрэг бөгөөд бизнесийн шударга өрсөлдөөний орчинг дордуулах үйл ажиллагаа тул хориглоно.
- 2.11. Аливаа салбарын зохицуулалтын журам болон үндсэн стандартыг тухайн салбарын мэргэжлийн холбоод хүчин төгөлдөрийн хууль тогтоомжийн хүрээнд тогтоож мөрдүүлдэг болгоно. Мөн тэдгээрийн орон нутгийн бизнесийн холбоодод орон нутагтаа салбарын бизнесийг зохицуулах, хяналт тавих эрхийг олгоно.
- 2.12. Мэргэжлийн холбоод, тэдгээрийн орон нутгийн салбарын өөрсдөө зохицуулах, хянах эрх олгогдсон асуудлаар Төрийн зүгээс аливаа тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих явдлыг зогсооно.
- 2.13. Банк санхүүгийн байгууллага, тендер зарлагч этгээд болон оюуны өмчийн бүртгэлийн байгууллага нь бусдын бизнесийн нууцыг дамжуулах, өөртөө ашиглахийг гэмт хэрэг гэж үзнэ. Иргэн, аж ахуйн нэгжийн зээл хүсэх,

3

00000003



Байгаль орчин, иргэний боловсрол нь тогтвортой хөгжлийн бат суурь гэж Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам үздэг ба дараах бодлогыг иргэдийн идэвхитэй оролцооны тусламжтайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. Хур тунадас багатай, гандуу хуурайгаас үүдэн гамшиг тохиолдох магадлалтай Монгол оронд эзэмшил газар болон бэлчээрийн ногоон бүрхүүлийг нэмэгдүүлэх “Хурын шим” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Усны хүртээмж багатай Монголд орны хувьд иргэд ганцаараа буюу хамтран өөрийн болон дундын эдэлбэр газарт ногоон байгууламж барих түүнийг хувийн хэвшлийн банк санхүүгийн байгууллагаас санхүүжүүлэх үйл ажиллагааг хөхиүлэн дэмжсэн хууль эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 3.2. Монгол орны байгаль цаг уур, газар зүйн нөхцөл байдлын онцлогт нийцсэн, цаг уурын өөрчлөлтөнд дасан зохицох аливаа үйл ажиллагааг иргэд хувийн хэвшилтэй хамтран шийдэж үр дүн гарч байгаа бол тэдгээр үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн зохион байгуулалтын ухаалаг дэмжлэг үзүүлнэ. Нэг удаагийн далайлтаар кампаничлах замаар аливаа тогтвортой шийдлийг устгадаг байдлыг таслан зогсооно.
- 3.3. Орчны бохирдлыг багасгахад иргэдийн оролцоотой, тогтвортой шийдлийг дэмжинэ. Иргэд бүтээх, боловсруулах үе шатанд нь оролцоогүй, хэрэглээнд нэвтэрсний дараа иргэдийн хариу үнэлгээнд суурилсан хөгжүүлэлт хийгдээгүй, Монгол орны эрс тэс уур амьсгалд 24 сараас доошгүй хугацаанд туршигдаагүй аливаа технологийг улсын төсвөөс санхүүжүүлэхгүй ба түүнд Засгийн газрын баталгаа гаргахгүй. Ногоон хөгжилд зориулсан болон орчны бохирдлын эсрэг бүтээгдхүүн нь эрс тэс уур амьсгал, хэрэглэгчдийн соёлд нийцэх эсэх нь 24 сарын ашиглалтын явцад нотлогдсон бол худалдан авалт, бусад хөнгөлөлтийн дэмжлэгт хамрагдана.
- 3.4. “Иргэдийн оролцоо - Нийтийн Хяналт”-ын соёлыг бүтээн байгуулалтын талбар болон орон нутгийн удирдлагад тавих иргэний хяналтыг хуульчилж нэвтрүүлнэ. Аливаа бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг иргэдийн оролцоогүйгээр шийддэг байдлыг хална.
- 3.5. Аливаа бүтээн байгуулалт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эхлэхээс хамгийн багадаа нэг жилийн өмнө үйл ажиллагаанд шууд өртөх иргэдтэй уулзалт, танилцуулга эхлүүлсэн байхыг хуульчилна. Хэрэв иргэдийн 85% нь дэмжвэл төслийг эхлүүлэх зөвшөөрлийг авах ба нөхөн төлбөрийн асуудлыг эрх ашиг нь хөндөгдөж буй талуудтай заавал тохирч, гэрээгээр баталгаажуулсан байхыг шаардана.
- 3.6. Эрх ашиг нь хөндөгдөж буй талд олгох нөхөн төлбөр болон орчны иргэдийн хөдөлгөөний нягтралд орж буй өөрчлөлтийг хэрхэн зохицуулах зэрэг асуудлыг тусгасан гэрээгүйгээр тухайн төслийн үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл өгсөн байвал иргэдтэй зөвшилцөөгүйн улмаас учирсан хор хохиролыг уг ажлыг эхлүүлэхийг зөвшөөрсөн албан тушаалтнаар төлүүлдэг болгоно.
- 3.7. Хэрэв Төрийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар аливаа бүтээн байгуулалт хийж буй бол тухайн бүтээн байгуулалтын байршил сонгох

5

00000075



асуудлаар заавал нийтийн сонсгол хийдэг болгоно. Төрийн байгууллагын санаачилгаар уг бүтээн байгуулалтыг хийх бол нээлттэй хэлэлцүүлэг, сонсголын зардлыг тухайн төслийн төсөвт тусгадаг байхаар хуульчилна.

- 3.8. Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл нь иргэдэд учрах гамшгийн аюулыг нэмэгдүүлж байвал уг төсөлд зөвшөөрөл өгөхийг хориглоно. Улс, орон нутгийн төсөв, олон улсын болон гадаад дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй аливаа төсөл, бүтээн байгуулалт нь тухайн орон нутгийн гамшгаас хамгаалах байнгын, үндсэн бүтцийг эвдэх, устгах, гамшгаас хамгаалах чадавхийг сулруулах, эсхүл ийм бүтэц байгуулахаар төлөвлөсөн байршлыг эзлэх, хааж хаших үр дагавартай байгаа бол уг төсөлд зөвшөөрөл олгохыг хориглоно. Хэрэв үүнийг зөрчиж зөвшөөрөл олгосон бол зөвшөөрөл олгосон бүх шатны албан тушаалтан, нийтийн аюулгүй байдлын өмнөөс төслийг хянаж нягтлах мэргэжлийн үүрэг хүлээсэн этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулдаг тогтолцоо нэвтрүүлнэ.
- 3.9. Гамшгаас хамгаалах байгууламжийг гэмтээх, өөрчлөх, эвдэх, устгах зөвшөөрөл өгсөн орон нутгийн төрийн захиргааны болон төрийн агентлагийн ажилтан, албан тушаалтныг төрийн албанаас чөлөөлж, дахин төрд ажиллуулах эрхийг хасна.
- 3.10. Баг, хорооны иргэдийн нийтийн хурал, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар сонгогдсон орон нутгийн засаг даргыг огцруулах эрхийг иргэдэд олгоно. Тухайн засаг даргыг сонгосон иргэдийн тооны 50 ба түүнээс дээш хувьтай тэнцүү иргэн гарын үсэг зурснаар засаг даргыг огцруулдаг хууль батална. Хэрэв засаг даргыг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар сонгосон бол уг хуралд засаг даргыг сонгохыг дэмжиж саналаа өгсөн төлөөлөгчдийг сонгосон нийт иргэдийн 50 хувьтай тэнцүү тооны иргэд гарын үсэг зурснаар тухайн засаг даргыг огцруулдаг байхаар хуульчилна.
- 3.11. Иргэний боловсрол, иргэд орчныхоо болон Монгол улсынхаа тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах шийдлийг харилцан зөвшилцөж гаргах үйл ажиллагааг иргэний нийгмээр дамжуулан дэмжинэ.

6

